



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

᠑᠔᠒2 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 1/᠒᠒.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалын хавсралт “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2 дугаар зүйлийн 2.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2012-2021 он хүртэлх Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийн цахим архив үүсгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга	Д.Бямбадорж	Эм үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Одбаяр	Эмийн үйлдвэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
	Б.Жишигжаргал	Шинэ эм, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичиг	Э.Баасандорж	Биологийн идэвхт бүтээгдэхүүн, протез, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Албан хаагчдыг ажлын бус цагаар ажиллуулах тохиолдолд хяналт тавьж ажиллахыг Агентлаг, хяналтын лабораторийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Н.Уянга)-д үүрэг болгосугай.

3. Илүү цагаар ажилласан хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль болон зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Болор-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422

01213